



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/277

Булган сум

“Гэрэл асаа” төслийн үйл ажиллагаанд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, “Амжилтын гараа хөтөлбөрийг батлах тухай” XI/76 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“ГҮҮД НЭЙБОРС ОУТББ”-ын өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих “Гэрэл асаа” төслийг хэрэгжүүлж байгаа Булган сумын Ерөнхий боловсролын 1 ба 2 дугаар сургуулийн сэтгэл зүйн зөвлөгөөний танхимыг засварлах, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн багш нарыг чадавхжуулах, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих кейс хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг үйл ажиллагаанд 10,000,000 (арван сая) төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Үйл ажиллагаанд шаардагдах зардлыг “Амжилтын гараа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3.Төслийг үр дүнтэй зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсролын газрын дарга (Ц.Цолмонбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010380